

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг 2023 оны байдлаар танилцуулж байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээг төлөвлөсөн.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-т заасан аргачлалаар, тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй тохиолдолд журмын 6.2.2-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн болно.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 47 зорилтод хамаарах 243 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны байдлаар **80.4** хувийн хэрэгжилттэй байна.

Бодлогын үндсэн 9 зорилгын хүрээнд хэрэгжилтийг авч үзвэл,

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл - 80.0 хувь,
2. Хүний хөгжил - 79.8 хувь,
3. Амьдралын чанар ба дундаж давхарга - 90.0 хувь,
4. Эдийн засаг - 84.0 хувь,
5. Засаглал - 60.8 хувь,
6. Ногоон хөгжил - 70.6 хувь,
7. Амар тайван, аюулгүй нийгэм - 91.7 хувь,
8. Бүс, орон нутгийн хөгжил - 82.1 хувь,
9. Улаанбаатар ба дагуул хот - 80.5 хувийн хэрэгжилттэй байна.

Нийт арга хэмжээний 32.1 хувь нь үр дүнтэй бүрэн хэрэгжсэн бол 43.2 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 19.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 5.3 хувь нь үр дүнгүй буюу 0.0 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд 2023 онд нийт 11.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд үүнээс “Эдийн засаг” зорилгын санхүүжилтэд 8.6 их наяд төгрөг, “Хүний хөгжил” зорилгын санхүүжилтэд 1.7 их наяд төгрөгийг зарцуулсан нь бусад зорилгын санхүүжилтээс илүү дүнтэй байна.

Түүнчлэн “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгыг хэрэгжүүлэхэд 762.0 сая төгрөг, “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгод 478.9 тэрбум төгрөг, “Засаглал” зорилгод 682.0 сая төгрөг, “Ногоон хөгжил” зорилгод 249.8 тэрбум төгрөг, “Амар тайван, аюулгүй нийгэм” зорилгод 275.8 тэрбум төгрөг, “Бүс, орон нутгийн

хөгжил” зорилгод 16.5 тэрбум төгрөг, “Улаанбаатар ба дагуул хот” зорилгод 160.3 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн байна.

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг эх үүсвэрээр авч үзвэл, улсын төсвөөс 3,130.9 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжаар 1,634.6 тэрбум, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн 4,878.7 тэрбум, Засгийн газрын тусгай сангаас 1,755.5 тэрбум, бусад эх үүсвэрээс 68.6 тэрбум төгрөг тус тус санхүүжсэн байна.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 94 шалгуур үзүүлэлтийг 2025 онд хүрэх түвшингээр тодорхойлж баталсан. Эдгээр шалгуур үзүүлэлтийн 26.6 хувь нь улсын хөгжлийг тодорхойлох ерөнхий үзүүлэлтүүд байгаа бол 73.5 хувь нь салбарын, байгууллагын, нутаг дэвсгэрийн хүрээнд авч үзэх байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой үзүүлэлтүүд байна. Нийт 94 шалгуурын 62 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, дунджаар 52.8 хувь байна.

Та бүхэн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлантай танилцана уу.